



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/А61

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны ХХV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Булган сумын нефть, нефтийн бүтээгдэхүүнээр бохирлогдсон газрыг эрүүлжүүлэх, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Био технологийн инкубатор" ХХК-тай 49,500,000 (Дөчин есөн сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, журам, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Био технологийн инкубатор" ХХК-ийн захирал (Ч.Батсүх)-д даалгасугай.

3. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль журам, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2024 оны
29-ны/ний өдрийн А/А31 дугаар
захиралтын хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээнд зааснаар	А.Гантөмөр
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	А.Гантөмөр Б.Бумцэнд
3	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Бумцэнд